



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ариг-Эрдэнэ ХХК-ийн “Холидей” зочид буудлын 17/093, “Нова” зочид буудлын 17/121, Сэц мэлмий ХХК-ийн “Шинэ өглөө” зочид буудлын 17/193, Цахиур төмөр сервис ХХК-ийн “Роял” зочид буудлын 17/232, Алтан Янзага ХХК-ийн “Рич Хилл” зочид буудлын 17/207, Цоглог инвест ХХК-ийн “Очир титэм” зочид буудлын 17/204, Алтаннаран трейд ХХК-ийн “Эрхэс” зочид буудлын 17/191, Цогт өргөө од ХХК-ийн “Цогт баян” зочид буудлын 17/210, иргэн Л.Бурмаагийн “Мини” дэн буудлын 17/201, иргэн С.Пүрэвдоржийн “Баянбүрд” дэн

1150500263

буудлын 17/186, иргэн Д.Мягмарсүрэнгийн “Комфорт” дэн буудлын 17/126 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг тогтоол шийдвэр, тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай..

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 10 өдрийн А/81 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.10

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ариг-Эрдэнэ ХХК	2543192	Холидей	БЗД-ийн 2-р хороо Б.Доржийн гудамж
2	Сэц мэлмий ХХК	5195411	Шинэ өглөө	БГД-ийн 5-р хороо 10 хороолол
3	Цахиур төмөр сервис ХХК	5819105	Рояал	БГД-ийн 5-р хороо 10 хороолол
4	Алтан Янзага ХХК	5478219	Рич Хилл	БГД-ийн 7-р хороо Далив хутагт Жамсранжавын гудамж 51
5	Цоглог инвест ХХК	2858886	Очир титэм	БГД-ийн 7-р хороо Ард Аюушийн гудамж
6	Алтаннаран трейд ХХК	2548542	Эрхэс	БГД-ийн 12-р хороо Хасбаатарын гудамж 5А-1
7	Ариг-Эрдэнэ ХХК	2543192	Нова	БГД-ийн 20-р хороо 1 хороолол
8	Цогт өргөө од ХХК	2857405	Цогтбаян	СБД-ийн 11-р хороо Цагдаагийн гудамж

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 10
сарын 10 өдрийн А/81 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.10.10

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Алтаннаран трейд ХХК	2548542	Мини	БГД-ийн 14-р хороо Хасбаатарын гудамж 18/1
2	Царам трейд ХХК	2777096	Царам	СБД-ийн 12-р хороо Хангайн 22-831
3	Найс Монголиа трейдинг ХХК	6149456	Баянбүрд	ЧД-ийн 6-р хороо Их тойруу
4	Миний Монголын наран ХХК	5905931	Комфорт	СХД-ийн 28-р хороо Ногоон чулуут 1-36